



Г

“НЭТС ПРОПЕРТИС” ХХК-Д

Г

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, <http://www.frc.mn>

2022.06.13 № ЦАТ-11/01/006
танай 2022.05.25 -ны № 22/55 -т

Г

Хаяг, байршлын өөрчлөлтийг
бүртгэсэн тухай

Г

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ын дагуу танай хаяг байршлыг өөрчлөлтийг бүртгүүлэх тухай хүсэлтийг хянаж “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ын дагуу хянаж “Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө гудамж, Хан-Уул товерийн 1002 тоот” гэж бүртгэлтэй байсныг “Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө гудамж, Хан-Уул товерийн 14 давхар 1402 тоот” гэж шинэчлэн бүртгэсэн болно.

Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5-д "Компанийн хаягийн өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгэх байгууллагад бүртгүүлнэ", Хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан журмын 6.9 дэх хэсэгт "Хаягийн өөрчлөлтийг бүртгэсэн бол тухайн зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад холбогдох тэмдэглэгээг хийнэ" гэж заасны дагуу улсын бүртгэлийн гэрчилгээнд хаягийн өөрчлөлтийг даруй хийлгэж Хорооны тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад дээрх хаягийн өөрчлөлтийн тэмдэглэгээг хийлгэнэ ҮҮ.

Компанийн хаяг, байршил өөрчлөгдсөнтэй холбоотойгоор харилцагч, үйлчлүүлэгчдэд сөргөөр нөлөөлөхгүй, төөрөгдүүлэхгүй байх талаар анхаарч ажиллахыг хүсье.

